


AGREEMENT ON ASSIGNMENT OF RIGHTS AND ASSUMING OBLIGATIONS	ЭРХ, ҮҮРЭГ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ
This Agreement on Assignment of Rights and Assuming Obligations (the "Agreement") has been concluded on _____ [Distributor to enter date], by and between the following parties:	Энэхүү ЭРХ, ҮҮРЭГ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ (цаашид "Гэрээ" гэх)-г _____ өдөр ("Дистрибьютороор элсэн орох өдөр")
1. Herbalife International of America, Inc., a company duly incorporated and validly existing under the laws of Nevada, United States of America, with its headquarters located at 800 W. Olympic Boulevard, Suite 406, Los Angeles, California 90015, and with its registered address at CSC Services of Nevada Inc., 502 East John Street, Carson, Nevada 89706, holding the Federal Tax I.D. number of 95-3954565, duly represented for the purpose of this agreement by Mr. Richard P. Goudis, in his capacity as Chief Operating Officer, hereinafter referred to as "Herbalife International of America" or "HIA";	1. АНУ-ын Невада мужийн хуулийн дагуу байгуулагдсан, Калифорни муж 90015, Лос Анжелес, 800 В. Олимпик Буливард, 406 тоот [800 W. Olympic Boulevard, Suite 406, Los Angeles, California 90015] хаягт үйл ажиллагаагаа эрхлэн явуулж буй толгой компанитай, Невада Инкийн СИ ЭС СИ Сервисез, Невада 89706, Карсон, Ийст Жоны Гудамж 502 [CSC Services of Nevada Inc., 502 East John Street, Carson, Nevada 89706] хаягт бүртгэгдсэн албан ёсны хаягтай (Татвар Төлөгчийн No. 95-3954565) Америкийн Хербалайф Интернэшнл Инк-ийг төлөөлж тус компанийн Үйл Ажиллагааны Ахлах Мэргэжилтэн ноён. РИЧАРД ГОУДИС (цаашид "Америкийн Хербалайф Интернэшнл" эсхүл "ЭЙЧ АЙ ЭЙ" гэх);
2. _____ [Distributor First and Second name], a natural authorized person, who will conduct its Herbalife business as a self-employed independent contractor (determining their own schedule and objectives, responsible for their own expenses and any applicable taxes including self-employment taxes), not as an employee, agent, franchisee, securities holder, joint venture, fiduciary or beneficiary of Herbalife or any other Distributor. He/she will not be an employee of Herbalife for tax purposes or any other purpose and will assert no position to the contrary. _____, Herbalife Identification No. _____ (hereinafter referred to as the "Distributor" or "DS")	2. Хербалайфын бизнесийн үйл ажиллагааг тус Компанийн ажилтан, төлөөлөгч, худалдаа үйлчилгээ явуулах зөвшөөрөл бүхий хувь хүн, хуулийн этгээд, хувьцаа эзэмшигч, хамтрагч, Хербалайф болон түүний албан ёсны Дистрибьюторын итгэмжлэгдсэн төлөөлөгчид болон хэрэглэгчдийн хэлбэрээр бус харин хувиараа, биеэ даасан гэрээлэгч хэлбэрээр эрхэлж явуулах эрх бүхий итгэмжлэгдсэн төлөөлөгч (бизнесийн зорилго, ажлын хуваарийг бие даан тодорхойлох, үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг бие даан хариуцах, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн татвар гэх мэт холбогдох татвар, хураамжийг бие даан төлөх) болох _____ (Дистрибьюторын нэр). Дистрибьютор нь орон нутаг, улсын хэмжээнд татвар төлөгч эсхүл ямар нэг өөр хэлбэрээр дээрх үйл ажиллагааг эрхэлж, үйлчилгээг үзүүлж буй Хербалайфын хөдөлмөрийн гэрээт ажилтан гэж өөрийгөө үзэхгүй болно. _____ ын Хербалайфын Хувийн ID дугаар. _____ (цаашид "Дистрибьютор" эсхүл "ДИ ЭС" гэх) болон
3. Herbalife Distribution Ltd., a company duly incorporated and validly existing under the laws of Cayman Islands, with its headquarters located at M&C Corporate Services Limited, P.O. Box 309GT, Ugland House, South Church Street, George Town, Grand Cayman, Cayman Islands, registered with the Trade Registry under no. 156241, duly represented for the purpose of this agreement by Mr. Stephen Conchie, in his capacity as Vice President, hereinafter referred to as "Herbalife Distribution" or "HDL"; hereinafter collectively referred to as the "Parties" and individually as the "Party".	3. Кэймоны Арлууд Улсын хуулийн дагуу байгуулагдсан, Кэймоны Арлууд Улс, Гранд Кэймон, Жорж Таун, Соуф Чөрч Гудамж, Юглэнд Хаус, Ш/Х 309 Жи Ти, ЭМ энд СИ Корпорэйт Сервисез Лимитед [M&C Corporate Services Limited, P.O. Box 309GT, Ugland House, South Church Street, George Town, Grand Cayman, Cayman Islands] хаягт үйл ажиллагаагаа эрхлэн явуулж буй толгой компанитай (Худалдааны Регистрийн #156241) Хербалайф Дистрибьюшн Лимитед-ийг төлөөлж тус компанийн Дэд Ерөнхийлөгч ноён. СТИВЕН КОНЧИ (цаашид "Хербалайф Дистрибьюшн" эсхүл "ЭЙЧ ДИ ЭЛ" гэх) нар дараах нөхцлүүдээр харилцан тохиролцож байгуулсан болно.(цаашид Гэрээний Талуудыг хамтад нь "Талууд" гэх ба тус тусад нь "Тал" гэх)

The Parties have agreed as follows:	Талууд доорх зүйлсийг харилцан тохиров:
Article 1 OBJECT OF THE AGREEMENT	Нэгдүгээр Зүйл. ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ
Starting with the date hereof, the Parties agree that HDL shall replace HIA in its contractual position in the Distributorship Application previously concluded with _____ [Distributor name] (hereinafter referred to as the "Novated Agreement") and that, as of such date, HDL shall enjoy all rights and be liable for all obligations resulting from the Novated Agreement as if HDL were the original contracting party to the Novated Agreement and a signatory party to such Novated Agreement. The Parties hereby agree that all rights and obligations of HIA resulting from the Novated Agreement shall be transferred to HDL at the date the Parties execute this Agreement. As of the execution date of this Agreement, all rights and obligations of the DS towards HIA under the Novated Agreement shall be exercised, respectively, fulfilled by the DS towards HDL as if HDL was an original party to the Novated Agreement.	Энэхүү Гэрээ байгуулагдсан өдрөөс эхлэн Хербалайф Дистрибьюшн нь албан ёсны Дистрибьютор болох хүсэлтийн дагуу _____ (Дистрибьюторын нэр)-тэй (цаашид "Эрх, Үүрэг Шилжүүлэх Гэрээ" гэх) өмнө нь байгуулсан гэрээгээр Америкийн Хербалайф Интернэшнлийг бүрэн орлохыг энэхүү Гэрээний Талууд хүлээн зөвшөөрсөн бөгөөд дээрх өдрөөс эхлэн Хербалайф Дистрибьюшн нь энэхүү Гэрээний анхдагч Тал болон энэхүү Гэрээг байгуулж гарын үсэг зурах бүрэн эрх бүхий Талын адилаар Эрх, Үүрэг Шилжүүлэх Гэрээний дагуу бүхий л эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Мөн Гэрээ байгуулагдсан өдрөөс эхлэн Эрх, Үүрэг Шилжүүлэх Гэрээний дагуу Америкийн Хербалайф Интернэшнлийн хүлэсэн бүхий л эрх, үүргийг Хербалайф Дистрибьюшнд шилжүүлэхийг Гэрээний Талууд бүрэн зөвшөөрсөн болно. Энэхүү Гэрээг байгуулсан өдрөөс эхлэн Дистрибьютор нь Хербалайф Дистрибьюшн-ийг энэхүү Гэрээний анхдагч Талтай адил хэмжээнд хүлээн авч түүний өмнө урьд нь Америкийн Хербалайф Интернэшнлийн өмнө Гэрээний дагуу эрх эдэлж, үүрэг хүлээж байсны адилаар Эрх, Үүрэг Шилжүүлэх Гэрээний дагуу бүхий л эрхийг эдэлж, үүргийг хүлээх болон биелүүлэх үүргийг хүлээнэ.
Article 2 OTHER CLAUSES	Хоёрдугаар Зүйл. БУСАД ЗҮЙЛҮҮД
HDL and the DS hereby agree that following execution of this Agreement the form of the Distributorship Application to govern their relationship is the one annexed to this Agreement, without, however, the DS losing its Herbalife Identification number priority awarded under the Novated Agreement and mentioned within the DS's identification details hereunder.	Хербалайф Дистрибьюшн болон Дистрибьютор нь энэхүү Гэрээг байгуулсан өдрөөс эхлэн Гэрээний дагуу өмнө нь Дистрибьюторт олгосон Хербалайфын Хувийн Дугаарыг үргэлжлүүлэн эзэмших болон энэхүү Гэрээнд Дистрибьюторын хувийн үйл ажиллагааны хүрээнд дурьдсаны дагуу Хербалайфын албан ёсны Дистрибьютор болох тухай өргөдлийн маягтийг Талуудын хоорондын харилцааг хянан зохицуулах зорилгоор энэхүү Гэрээнд хавсаргахыг харилцан хүлээн зөвшөөрсөн болно.
This Agreement shall be governed by and construed in accordance with the Mongolian laws.	Энэхүү Гэрээ нь Монгол Улсын хуулийн дагуу тайлбарлагдан зохицуулагдана.
Any dispute arising out of or in relation to this Agreement shall be settled by the competent courts of Mongolia.	Энэхүү Гэрээтэй холбогдон гарах аливаа маргааныг Монгол Улсын эрх бүхий шүүхийн байгууллагуудаар шийдвэрлүүлнэ.
This Agreement is executed in (3) three counterparts in Mongolian and English languages, one counterpart in each language for each Party, each of which shall be deemed an original but all of which constitute one and the same instrument. In case of any inconsistency between the Mongolian and English version, the English version shall prevail.	Энэхүү Гэрээг Монгол, Англи хэл дээр тус бүр 3 эх хувиар үйлдэх ба эх хувиуд бүгд нийлээд нэгдмэл нэг Гэрээг бүрдүүлнэ. Тал тус бүр Монгол, Англи дээр үйлдсэн нэг нэг эх хувийг авч хадгална. Дээрх Гэрээний Монгол, Англи хэл дээр үйлдсэн хувиудын хооронд ямар нэг зөрөлдөөн үүссэн тохиолдолд Англи хэл дээрх хувь давамгайлна.

For and on behalf of HIA / Америкийн Хербалайф Интернэшнлийг төлөөлж	For and on behalf of HDL / Хербалайф Дистрибьюшн ийг төлөөлж	For and on behalf of the Distributor / Дистрибьюторыг төлөөлж
Name / Нэр Richard P. Goudis Ричард П. Гоудис 	Name / Нэр Stephen Conchie Стивен Кончи 	First and Second name / Овог, нэр Signature / Гарын үсэг
Title / Албан тушаал Chief Operating Officer / Үйл Ажиллагааны Ахлах Мэргэжилтэн	Title / Албан тушаал Vice President / Дэд Ерөнхийлөгч	[to be completed] / [Нэрийг бөглөж бичих]

Хербалайф Дистрибьюшн Лимитед
ЭМ энд СИ Корпорейт Сервисес Лимитед
Кеймоны Арлууд Улс
Жорж Таун Гранд Кеймон
Саус Черч Гудамж
Юглэнд Хаус
Ш.Х-309 Жи Ти

Монгол дахь хаяг нь:
Юниверсал Логистикс Монголия ХХК
Саруул төв, Нарын зам-53
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар 14252
Монгол Улс
Утас: +976 77008891
Факс: +976 77008893
И-мэйл: drmongolia@herbalife.com

ОЛОН УЛСЫН АЛБАН ЁСНЫ ДИСТРИБЬЮТОРЫН ӨРГӨДЛИЙН МАЯГТ
APPLICATION FOR DISTRIBUTORSHIP

Өргөдөл нь зөвхөн Монгол хэлээр бүрэн бүтэн дарааллаар бөглөгдсөн байх ба зөвхөн энэ тохиолдолд Хербалайф Дистрибьюшн Лимитед өргөдлийг хүлээн авна
Application must be completed accurately in Mongolian language and in its entirety in order to be considered by Herbalife Distribution Ltd.

ДИСТРИБЬЮТОРЫН ХУВИЙН ДУГААР /
IDENTIFICATION NUMBER

Таны гаргасан хүсэлт
хүлээн зөвшөөрөгдсөний дараа
танд олгогдох Хербалайфийн Дугаар
The number above is your Herbalife ID Number
once your Application is accepted.

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ / APPLICANT INFORMATION

Овог / Last Name	Нэр / First Name	Дунд Нэрийн Эхний Үсэг / Middle Initial
Гудамжны Хаяг (Ш.Х №/Орон Нутгийн Замын Бүртгэлийн №) Ш.Х-ны дугаартай бол доорхи зайнд албан ёсны байнгын оршин суух (хууль ёсны/татвар төлөгчийн) хаягийг заавал бичнэ үү. Street Address (P.O. Box) If P.O. Box indicated, Legal/Fiscal Residence Address must be completed below.		
Хот / City	Шуудангийн Код / Postal Code	
Улсын Код Country Code	Өдрийн цагаар холбоо холбоо барих утас Day Phone	Оройн цагаар холбоо барих утас Evening Phone
Гар Утас Mobile Phone	Төрсөн Огноо (өдөр) Date of Birth (day)	(сарыг үсгэлж бичих) (month - spelled out)
И-мэйл хаяг (шаардлагатай бол) Та И-мэйл хаягаа гагцхүү өөрийн хэрэглээнд ашиглах ба өөр бусад Дистрибьюторүүдтэй хамтран эзэмшиж болохгүй. Та өөрийн И-мэйл хаягаа бидэнд өгснөөр та Хербалайф Компаниас бизнесийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл бүхий И-мэйлийг хүлээн авахыг албан ёсоор зөвшөөрч байна. / Email Address (if applicable). Your email address must be unique and not shared by another Distributor. By providing your email address, you have consented to receive business-related email communications from Herbalife.		
Иргэний үнэмлэхийн дугаар National ID Card/Passport Number	эхнэр/нөхөрийн иргэний үнэмлэхийн дугаар Spouse National ID Card/Passport Number	
Эхнэр/Нөхрийн Овог Нэр Spouse's Last Name	Нэр First Name	Дунд Нэрийн Эхний Үсэг Middle Initial

АЛБАН ЁСНЫ БАЙНГЫН ОРШИН СУУХ ХАЯГ (дээрхи хаягаас өөр бол) / LEGAL/FISCAL RESIDENCE ADDRESS (IF DIFFERENT FROM ABOVE)

Гудамжны Хаяг (Ш.Х-аас өөр байх) / Street Address (cannot be a P.O. Box)			
Хот / City	Шуудангийн Код / Postal Code		
Улсын Нэр Country	Улсын Код Country Code	Бүсийн Код Area Code	Утасны Дугаар Phone Number

СПОНСОРЫН (SPONSOR) ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ / SPONSOR'S INFORMATION

DO NOT FILL / ЭДГЭЭР ХЭСГИЙГ БӨГЛӨХГҮЙ

ХЯНАГЧИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ / SUPERVISOR'S INFORMATION

DO NOT FILL / ЭДГЭЭР ХЭСГИЙГ БӨГЛӨХГҮЙ

☐ Би Хербалайф-ийн бизнесийн үйл ажиллагааны явц ба бараа бүтээгдэхүүний тухай мэдээ мэдээллийг хүлээж авахыг хүсэхгүй байна. Энэхүү сонголтыг хийснээр би өөрийн Дистрибьюторын байр суурийг сулруулах эрсдэлтэй алхам хийж байгаа гэдгээ хүлээн зөвшөөрч байна. (үл сонгох)

☐ Би Хербалайф-ийн хамрагчдынхаа нэрийн өмнөөс шуудангаар илгээсэн бизнесийн үйл ажиллагааны явц ба бараа бүтээгдэхүүний тухай мэдээ мэдээллийг хүлээж авахыг хүсэхгүй байна. Энэхүү сонголтыг хийснээр би өөрийн Дистрибьюторын байр суурийг сулруулах эрсдэлтэй алхам хийж байгаа гэдгээ хүлээн зөвшөөрч байна. (үл сонгох)

☐ Хербалайф нь өөрийн бизнесийн хамрагчдын нэрийн өмнөөс бизнесийн үйл ажиллагааны явц ба бараа бүтээгдэхүүний тухай мэдээ мэдээллийг и-мэйлээр илгээж болно. Энэхүү үл сонгох гэсэн сонголтыг хийснээр би өөрийн Дистрибьюторын байр суурийг сулруулах эрсдэлтэй алхам хийж байгаа гэдгээ хүлээн зөвшөөрч байна. (сонгох)

Та энэхүү гэрээнд гарын үсэг зурсан тохиолдолд Та 14 хоногийн хугацаанд цуцлаж мөнгөө буцааж авах боломжтой юм.

Өргөдөл гаргагчийн гарын үсэг:

Би гэрээний дээр болон арын хуудсанд бичигдсэн бүх нөхцлийг хүлээн зөвшөөрч байна.

Гарын үсэг зурсан: _____ Огноо _____
Хот/аймаг, Улс _____ Өдөр _____ Сар _____ Он _____

Стивен Кончи
Herbalife компанийн Дэд ерөнхийлөгч

Хуваарилалт: Цагаан 1 ба 2 дугаар хуудас- Хербалайфын хуулбарууд Ягаан
Distribution: White- Herbalife's copies

Спонсорын хуулбар Цайвар шар
Pink- Sponsor's copy

Супервайзорын хуулбар Цэнхэр
Blue- Supervisor's copy

Өргөдөл гаргагчийн хуулбар
Candy- Applicant's copy

Энэ хуудсыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хэвлэх ба хэрэглэх нь хуульд харш үйлдэл болно. Reproduction of this page in whole or in part is illegal.
© 2011 Хербалайф Дистрибьюшн Лимитед, албан ёсоор бүртгэгдсэн. Бүх эрх хамгаалагдсан болно.

4021-MG-01 Rev. 07/11

АЛБАН ЁСНЫ ДИСТРИБЬЮТОР БОЛОХ ТУХАЙ ГЭРЭЭ / AGREEMENT OF DISTRIBUTORSHIP

- Өргөдөл гаргагч нь энэхүү Албан Ёсны Дистрибьютор (Дистрибьютор) Болох Тухай Гэрээ, түүнийг дагалдах бусад бүх баримт бичгүүд болон энэхүү өргөдлийн маягтийн арын хуудсанд дурьдсан нөхцлүүдийн дагуу Хербалайфын бүтээгдэхүүнийг борлуулах бие даасан дистрибьютор болохыг хүсч энэхүү өргөдлийг гаргах байгаа болно. Хербалайф нь Дистрибьютор болохыг хүссэн энэхүү өргөдлийг гагцхүү цэвэр өөрийн үзэмжээр баталж хүлээн зөвшөөрсний үндсэн дээр Өргөдөл гаргагч нь тус Компанийн Дистрибьютор болох бөгөөд тэр хүртэл Өргөдөл гаргагч нь Хербалайфын бараа бүтээгдэхүүнийг түр хугацаат зөвшөөрлийн дагуу худалдах, худалдан авах эрхтэй болно.
 - Өргөдөл гаргагч эсхүл түүний эхнэр/нөхөр өмнө нь Хербалайфын Дистрибьютор байсан эсвэл дистрибьюторын үйл ажиллагаанд ямар нэг хэлбэрээр оролцон дэмжлэг туслалцаа үзүүлж байсан тохиолдолд доорхи хэсгийг бөглөнө.
Дистрибьюторын Хувийн Дугаар/Нэр/Өргөдөл гаргасан огноо: ____/____/____.
Дистрибьюторын үйл ажиллагааг хамгийн сүүлд эрхэлж байсан огноо: ____/____/____.
Компанийн үйл ажиллагааны журам болон Дистрибьюторын баримтлах бодлогын дагуу Дистрибьюторын үйл ажиллагаа эрхлэх эрхийг доорх тохиолдолд 1 жилийн хугацаатайгаар түр зогсоохыг Өргөдөл гаргагч хүлээн зөвшөөрч байна. Үүнд:
(a) жилийн төлбөрийг төлөөгүй, эсхүл
(b) өмнөх Дистрибьюторын үүргээс чөлөөлөгдсөн.
Өргөдөл гаргагч нь дээрх хугацаа дуусгавар болсныг Хербалайфт үүгээр баталж байна.
Өргөдөл гаргагч нь өөрийн эхнэр/нөхрийн хамт Хербалайфын Дистрибьюторын түр үйл ажиллагааг эрхлэхийг хүсч гаргаж буй энэхүү өргөдлөөс гадна өөр бусад Хербалайфын Дистрибьюторын үйл ажиллагааг давхар эрхлэхгүй гэдгээ хүлээн зөвшөөрч байна. Дээр дурьдсан дахин Хербалайфын үйл ажиллагааг эрхлэхийг хугацаатайгаар түдгэлзүүлсэнтэй холбоотой журмыг зөрчсөн тохиолдолд өмнөх Дистрибьюторын эрхийг сэргээх болон Шинэ Спонсороор элсэн орж Гэрээ байгуулахын төлөө хүлээж хугацааг уртасгахад нөлөөлнө.
Дээрхи хүлээгдэх хугацаанаас өмнө гаргасан аливаа өргөдөл нь хүчингүйд тооцогдож болно. Спонсорын холбоог хамгаалахад авах арга хэмжээнүүд нь том хүрээний сүлжээ болон санхүү, мөнгөний асуудал эсхүл торгууль болон хүчингүй болсон Дистрибьюторын эрхийг цуцлахад нөлөөлж болох ба эдгээрийг Хербалайф нь гагцхүү өөрийн үзэмжээр шийднэ.
 - Өргөдөл гаргагч нь дор дурьдсан зүйлсийг хүлээн зөвшөөрч баталж байна:
 - Хербалайф Интернейшнлийн тайлбар материал, маягтууд болон Хербалайфын бараа бүтээгдэхүүнээс бүрдсэн шинэ Бизнес Багц (Herbalife International Business Pack ("IBP"))-ыг хүлээн авч зохих ёсоор танилцсан болно.
 - Санхүүгийн хувьд хүрч болох амжилтаас хамаарсан ямар нэг мэдээлэл ба төлөвлөлд найдвар тавихгүй болно.
 - Хербалайфын бие даасан Дистрибьютор болох, үйл ажиллагаагаа амжилттай явуулах болон цаашид ахин дэвжихэд худалдах авах шаардлагатай цорын ганц зүйл нь Олон Улсын Бизнес Багц (ОУББ) гэдгийг зүй ёсоор мэдсэн болно.
 - Хербалайфын Олон Улсын Бизнес Багц (ОУББ) нь тус Компанийн Үйл Ажиллагааны Журам ба Дистрибьюторын Баримтлах Бодлого, Борлуулалт ба Маркетингийн Төлөвлөгөө, Бүтээгдэхүүн Захиалах Журам болон Маягтын Загварууд (болон бусад зүйлс) зэрэгээс бүрдэнэ. Дээрх баримт бичгүүд болон Хербалайфаас хэвлэн гаргасан эсхүл ирээдүйг гарах бусад дүрэм журам, бодлогууд нь шаардлагатай тохиолдолд Компанийн өөрийн үзэмжээр тэдгээрт оруулсан нэмэлт өөрчлөлтүүд (хамтад нь "Дүрэм" гэх)-ийн хамт энэхүү Дистрибьютор Болох Тухай Гэрээ (тэдгээр дүрэм, журам тус бүр нь хамгийн сүүлд батлагдан хэвлэгдэж гарсан маягтуудын хувийд байх)-г бүрдүүлэх ба Гэрээний салшгүй хэсэг болно.
 - Дистрибьюторын эрх нь 1 жилийн хугацаанд хүчинтэй байх ба Хербалайфын зүгээс цэвэр өөрийн үзэмжээр тогтоосон үйлчилгээний төлбөрийг төлсөн эсэх, тогтоосон дүрэм журам, шаардлагад нийцсэн эсэхээс хамааран жил тутам албан ёсоор сунгагдана. Дистрибьюторын үйл ажиллагааг эрхлэх эрхийг Хербалайфд урьдчилан бичгээр мэдэгдсэний үндсэн дээр цуцлан дуусгавар болгож болно. Дээрхи эрх цуцлагдсаны дараа Дистрибьютор нь Дүрэмд тусгасан нөхцлүүд болон холбогдох бусад хязгаарлалтуудтай нийцүүлэн Хербалайфаас худалдаж авсан бүрэн бүтэн, заргаагагүй бараа бүтээгдэхүүн болон ОУББ-ын ашиглагдаагүй хэсгийг үргэлжлүүлэн зарж борлуулах эрхийг хэвээр эдэлнэ.
 - Дистрибьютор нь энэхүү Гэрээний аль нэг зүйлийг зөрчсөн тохиолдолд Хербалайф түүний үйл ажиллагаа эрхлэх эрхийг цуцлах шийдвэр гаргаж болно (Дүрэм болон холбогдох бусад хууль, тогтоомж зэргээр хязгаарлагдахгүйгээр).
 - Хербалайфын бие даасан Дистрибьютор нь дараахь үүргийг хүлээнэ:
 - Хербалайфын нэр хүндийг өсгөх зорилготойгоор Хербалайфын бараа бүтээгдэхүүнийг хэрэглэгч, худалдан авагчдад зарах, борлуулах болон сурталчлахын төлөө бүхий л хүчээ дайчлан хүчин зүтгэж чармайн ажиллана. Дистрибьюторын ашиг, орлого ба амжилт нь Хербалайфын бараа бүтээгдэхүүний борлуулалтын хэмжээ болон тухайн Дистрибьюторын шууд ба шууд бус байдлаар элсэн оруулсан спонсоруудаас хамаарна.
 - Дистрибьютор нь бусдыг хууран мэхлэх хууль бус бөгөөд шударга бус ямар нэг үйлдэл хийхийг хориглоно. Энэхүү Гэрээ болон холбогдох бусад хууль, тогтоомжийг зөрчсний улмаас Хербалайфт учруулсан аливаа гэм хор, хохирлыг нөхөн төлөх болон түүнээс үүдэн гарч болох бусад хариуцлагыг Дистрибьютор бүрэн хүлээнэ. Хербалайфт учруулсан аливаа хохиролтой тэнцэхүйц хэмжээний нөхөн төлбөрийг тус Компаниас Дистрибьюторт төлөх ёстой төлбөрөөс суутган авна.
 - Дистрибьютор нь Хербалайфын бизнесийн үйл ажиллагааг тус Компанийн ажилтан, төлөөлөгч, худалдаа үйлчилгээ явуулах зөвшөөрөл бүхий хувь хүн, хуулийн этгээд, хувьцаа эзэмшигч, хамтрагч, Хербалайф болон түүний албан ёсны Дистрибьюторын итгэмжлэгдсэн төлөөлөгчид болон хэрэглэгчдийн хэлбэрээр бус харин хувиараа, биеэ даасан гэрээлэгч хэлбэрээр эрхэлнэ (бизнесийн зорилго, ажлын хувиарийг бие даан тодорхойлох, үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг бие даан хариуцах, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн татвар гэх мэт холбогдох татвар, хураамжийг бие даан төлөх). Дистрибьютор нь орон нутаг, улсын хэмжээнд татвар төлөгч эсхүл ямар нэг өөр хэлбэрээр дээрх үйл ажиллагааг эрхэлж, үйлчилгээг үзүүлж буй хөдөлмөрийн гэрээт ажилтан гэж өөрийгөө үзэхгүй болно.
 - Дистрибьютор нь өөр бусад этгээдийг зохих хууль тогтоомж, ёс зүйн дагуу Дистрибьютороор элсүүлж оруулахын зэрэгцээ худалдан авагч, хэрэглэгчдэд Хербалайфын бараа бүтээгдэхүүнийг зарах, борлуулах болон сурталчлах үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн эрхлэх ба шинээр элсэн орсон Дистрибьюторуудыг дээрх үйл ажиллагааг амжилттайгаар эрхлэн явуулахад сургах, тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлэх болон тэднийг үлгэр жишээнд байдлаар удирдан зохион байгуулахын төлөө бүхий л хүчээ дайчлан хүчин зүтгэж чармайн ажиллана. Хербалайфаас тогтоосон Дүрэм болон холбогдох бусад хууль, тогтоомжид тусгайлан зааснаас бусад тохиолдолд Хербалайфын бараа бүтээгдэхүүнийг зарж сурталчлах болон өөр бусад байдлаар ашиг орлого олох боломж бололцоог эрэлхийлэх талаар ямар нэг үйлдэл хийхгүй болно. Дистрибьютор нь Хербалайфын бараа бүтээгдэхүүний борлуулалтаас олох ашгийн төлөө бус харин өөрийн худалдан авагч, хэрэглэгчдийн хэрэглээ болон шаардлагын хүрээ, хэм хэмжээнд тохируулан бараа, бүтээгдэхүүнийг захиалж авна.
 - Бүтээгдэхүүн Импортлогчийн (нийлүүлэгчийн) Хаягийг баталгаажуулан Хербалайфын Дистрибьюторуудын тухай тодорхой мэдээллүүдийг цуглуулж ОХУ, Москва 129110, Мирын Өргөн Чөлөө, #33/1 хаягт бүртгэлтэй "Хербалайф Интернейшнл" ХХК-д хүргүүлнэ. Ингэснээр тус Компани нь Дистрибьютортой байгуулсан гэрээ, хэлцлийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлж тухайн Дистрибьюторыг түүний захиалсан бараа бүтээгдэхүүн болон бусад үйлчилгээгээр хангана. Дистрибьюторын талаарх мэдээллүүд нь тэднийг Хербалайфын бизнесийн үйл ажиллагаагаа эрхлэн явуулахад шаардлагатай материалууд болон Хербалайфын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ эсхүл түүний бизнесийн хамтрагчдын зах зээлд гаргасан бараа бүтээгдэхүүн болон холбогдох бусад мэдээ мэдээллүүдийг хамарсан Хербалайфын бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээллүүдийг илгээхэд хэрэглэгдэж болно. Дээрхийг зөвшөөрөх эсвэл эс зөвшөөрөх эсэхээ энэхүү Өргөдлийн Маягтийн нүүр хуудсанд тусгайлан заасан хэсгийг (3 нүдийг тэмдэглэх) бөглөж мэдэгдэнэ. Тус Компанийн нууцлалын бодлогын талаарх нэмэлт мэдээллийг Олон Улсын Бизнесийн Гарын Авлагаас авч үзэж танилцана уу.
 - Дистрибьютор нь Хербалайфын үйл ажиллагааг эрхлэх хугацаанд дараахь үүргийг хүлээнэ:
 - Дистрибьютор нь өөрийн эхнэр/нөхөр-ийн хамт Хербалайфын бараа, бүтээгдэхүүнийг худалдаа арилжаа, дүрэм журам, бизнес төлөвлөгөө болон Компанийн бизнесийн үйл ажиллагааны талаарх бүхий л мэдээллүүд (үүнд Компанийн албан ёсны Дистрибьютор болон бусад хэрэглэгчид, үйлчлүүлэгчдийн талаарх бүхий л мэдээллүүд орох боловч түүгээр хязгаарлагдахгүй), Хербалайфын зүгээс ил болгосон ба Дистрибьютор болон бусад хэрэглэгчид, үйлчлүүлэгчдийн бизнесийн хувьд үнэ цэнэтгйд тооцогдох өөр бусад мэдээллүүд болон тухайн Дистрибьюторын үйл ажиллагаагаа эрхэлж буй хугацаандаа өөрөө олж мэдэж бусад мэдээллүүдийг эдийн засгийн хувьд чухалд тооцогдож болох бүхий л хугацааны туршид чандлан хадгалж тэдгээрийг шууд ба шууд бус хэлбэрээр өөрийн бизнесийн үйл ажиллагааг явуулахаас өөр бусад зорилгоор ашиглахгүй байх үүргийг хүлээнэ.
 - Дистрибьютор нь өөрийн эхнэр/нөхөр-ийн хамт энэхүү Гэрээг байгуулснаас хойш нэг (1) жилийн туршид (өөр бусад этгээд, хувь хүн, хуулийн этгээд болон ямар нэг заль мэх ашиглан) Дистрибьюторын үйл ажиллагаа эрхэлж байх хугацаандаа ажил хэргийн хүрээнд харилцаанд орсон өөр бусад Дистрибьюторууд болон Хербалайфын хэрэглэгчид, үйлчлүүлэгчдийг шууд ба шууд бус хэлбэрээр элсүүлэх, хөглөх, зуучлах эсвэл сурталчлах, зах зээлийн бүх түвшнийг хамарсан гараас гарт шууд дамжуулан борлуулах бизнес эрхлэгч компаниудтай хамтран ажиллах, тэдгээрийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, худалдах, худалдан авах, эсвэл тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох (борлуулгач эсвэл өөр бусад хэлбэрээр) болон өөрийн хүлээсэн үүргээс гадур аливаа үйлдлийг өөр бусад этгээдүүдийг хийхийг хөхүүлэн дэмжихгүй байх үүргийг хүлээнэ.
 - Дистрибьютор нь Хербалайфын брэнд нэр, лого, барааны тэмдэг болон оюуны өмч зэргийг Хербалайфын бичгээр үйлдсэн зөвшөөрлийн дагуу тусгайлан заасан хэм хэмжээний хүрээнд ашиглана.
 - Дистрибьютор нь өөрийн эрх, үүргийг Дүрэмд өөрөөр зааснаас бусад тохиолдолд сайн дураараа болон албадлагаар бусад шилжүүлэх эрхийг бөгөөд тэдгээрийг гагцхүү Хербалайфаас урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөл (шилжүүлэх тохиолдолд Хербалайф-аас тусгайлан заасан нөхцлүүдийг мөрдөх)-ийн дагуу шилжүүлнэ. Тэрхүү зөвшөөрлийг олгох ба эс олгох эсэхийг Хербалайф нь дангаараа бөгөөд зөвхөн өөрийн үзэмжээр шийднэ.
 - Хербалайф нь айл өрх, гэр бүлд чиглэгдсэн бизнесийн үйл ажиллагаа бөгөөд Дистрибьютор нь дээд зэргийн ёс зүй болон үнэнч шударга байдлыг эрхэмлэн үйл ажиллагаагаа явуулах үүрэг хүлээнэ. Дистрибьютор нь ямар нэг гэмт хэргт холбогдож байгаагүй гэдгээ үүгээр баталж байна.
 - ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ БОЛОН ХЯЗГААРЛАЛТ. Аливаа хүчин төгөлдөр үйлчилж буй холбогдох хууль, тогтоомж болон түүнтэй тэнцэхүйц зарчим, бодлого эсхүл эрх бүхий байгууллагаас тогтоосон дүрэм журмаас үл хамааран Хербалайфын үйл ажиллагаатай холбогдон гарсан аливаа маргааны талаарх гомдол нэхэмжлэлийг нэхэмжлэгч хувь хүн болон хуулийн этгээд нь түүнийг илрүүлсэн өдөр эсхүл тухайн маргаантай асуудал нь холбогдох хяналт шалгалтаар илэрсэн өдрөөс хойш нэг (1) жилийн дотор гаргана. Энэхүү Гэрээ болон Гэрээний талуудын хоорондын харилцаа, бизнесийн үйл ажиллагаатай холбогдон гарсан аливаа маргааныг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хүрээнд Монгол Улсын эрх бүхий шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 12. БУСАД ЗҮЙЛҮҮД:**
- Хербалайф болон Дистрибьюторын аль аль нь энэхүү Гэрээг цуцлах, түүнийг хэрэгжилтийг түдгэлзүүлэх эсхүл Гэрээг зөрчсөний улмаас учирсан аливаа гэм хор, хохирол болон бусад гарч болзошгүй үр дагаврын төлөө хариуцлага хүлээхгүй болно. Хүчин төгөлдөр үйлчилж буй холбогдох хууль, тогтоомжид өөрөөр тусгайлан заагаагүй л бол Талууд нь тухайн хохирлыг урьдчилан мэдэх боломжтой байсан эсэхээс үл хамааран Гэрээний аль ч Тал нь Талуудын хооронд гарсан маргааны улмаас учирсан хохирлыг нөгөө Талд нөхөн төлөх үүрэг хүлээхгүй болно.
 - Хербалайф ба Дистрибьюторын хооронд байгуулсан энэхүү Гэрээ болон түүнийг дагалдах бусад бүх баримт бичгүүд (тухайн үед хэвлэгдэн, үйлдэгдэн гарсан) нь нийлээд нэгдмэл нэг Гэрээг бүрдүүлнэ.
 - Эрх бүхий шүүхийн байгууллагын зүгээс энэхүү Гэрээний аль нэг зүйлийг хүчингүй, хууль бус болон ямар нэг байдлаар хэрэгжүүлэх боломжгүй гэж үзсэн тохиолдолд хүчингүй, хууль бус болон хэрэгжүүлэх боломжгүй гэж үзсэн Гэрээний тэрхүү зүйлүүд нь хуулийн дагуу хүчин төгөлдөр буст тооцогдох бөгөөд Гэрээний хүчин төгөлдөр үйлчилж буй бусад зүйлүүдэд ямар нэг байдлаар нөлөөлөх өсгүй болно.
 - Энэхүү Гэрээний Талууд, тэдгээрийн эрх залгамжлагчид нь өөрсдийн ашиг сонирлын төлөө Гэрээгээр хүлээсэн үүргээ хичээнгүйлэн биелүүлнэ.
13. Хербалайфын бие даасан дистрибьютор нь өөрөө болон эхнэр/нөхөр өөрсдийн үйл ажиллагаанд нь шууд ба шууд бус байдлаар туслалцаа үзүүлдэг бусад хувь хүн аль нь (шууд хувь хүнээр, аж ахуйн нэгжээр дамжуулан) Хербалайфын үйл ажиллагааг (1) Иран, Судан, Куб болон БНСАУ зэрэг орны иргэдтэй (үүнд цэвэр оршин суугчид ба (2) Иран, Судан, Куб болон БНСАУ зэрэг улсуудад бизнесийн үйл ажиллагаа явуулдаг (3) эсвэл Иран, Судан, Куб болон БНСАУ иргэдэд амжилттай худалдаа явуулж чадна хэмээн итгэж буй хүмүүстэй) хамтын үйл ажиллагаа явуулахад хүрээнд дараах зарим хязгаартай болно, үүнд:
- Хербалайфын бизнес боломжуудыг сурталчлах
 - Хербалайфын дистрибьюторыг спонсорлох
 - Хербалайфын бүтээгдэхүүнийг сурталчлах, худалдах; эсвэл
 - Энэхүү дүрмээр хориглосон зүйлийг үл тоомсорлон үйл ажиллагаа явуулахыг хөхүүлэн дэмжих.
- Дээрх дүрмүүдийг зөрчсөн тохиолдолд Дистрибьюторыг гэрээг цуцлах болно.

ЦУЦЛАЛТЫН ХЭСЭГ (ТА ГЭРЭЭГ ЦУЦЛАХЫГ ХҮССЭН ТОХИОЛДОЛД ҮҮНИЙГ БӨГЛӨЖ, САЛГАН ИРҮҮЛНЭ ҮҮ)

Би Дистрибьюторын Гэрээг цуцлахыг хүсч байгаагаа энд батлаж байна.

_____(Хербалайфын Хувийн ID дугаараа бичнэ үү)

Гарын үсэг зурсан _____